

Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтэс
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;	-	-	-	-	-	Монгол Улсын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан. Энэ хүрээнд Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн судалгаа болон нэгдсэн төсвийн орлого, зарлага болон хөрөнгө оруулалтын өмнөх онуудын гүйцэтгэл, нөхцөл байдлын дүн шинжилгээ, цаашдын чиг хандлага болон дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын талаар танилцуулгыг боловсруулж, холбогдох танилцуулгад тусган ажилласан. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг Монгол	100%	100%

							Улсын Засгийн газар, холбогдох байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Хавсралт: 3 файл		
3.1.1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Үйл ажилл агааны зардла ар	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхой лох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгө ө" батлагдса н.	-	Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулга д тусгах. /1 танилцуулга /	Монгол Улсын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан. Энэ хүрээнд 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай нэгдсэн төсвийн орлого, зарлага, улсын төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх онуудын гүйцэтгэл, нөхцөл байдлын дүн шинжилгээ, цаашдын чиг хандлага, мөн дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлон холбогдох танилцуулгад тусган ажилласан. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг Засгийн газар болон холбогдох байнгын хороодоор хэлэлцэж, Улсын Их Хурлын 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Хавсралт: 3 файл	100%	100%

3.2.	Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл хийх	-	-	-	-		Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай төсвийн секторын өнөөгийн нөхцөл байдал, төсөөллийг боловсруулж холбогдох тайлан, танилцуулга боловсруулсан. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгад нэгдсэн төсвийн орлого, зарлага болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2026 оны төсөөллийг боловсруулж, тусгасан. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар, холбогдох байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Дунд хугацаанд үр ашиггүй төсвийн урсгал зардлыг бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог үе шаттай багасгах төсвийн бодлогыг тодорхойлж, холбогдох дэлгэрэнгүй танилцуулга, тэргүүлэх чиглэлд тусгасан болно. Хавсралт: 4 файл	100%	100%
3.2. 1	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө	Үйл ажилл агааны	Тооцоо, төсөөллийн	Монгол Улсын Их Хурлын	Эдийн засгийн 2026 оны тооцоо	-	Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд нэн шаардлагатай	100%	100%

	<p>боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.</p>	<p>зардлар</p>	<p>тусгасан танилцуулгын тоо</p>	<p>2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.</p>	<p>төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/</p>		<p>салбарын реформ, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах замаар ядуурлыг бууруулж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд төрийн үйлчилгээг хялбаршуулах, чиг үүргийн давхардлыг арилгах замаар төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байх, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах чиглэлд төсвийн зардлын реформыг хэрэгжүүлэхээр тусган боловсруулсан. Мөн макро эдийн засгийн нөхцөл байдлын танилцуулгад 2024 он, 2025 оны төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, тусган боловсруулсан. Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр батлагдсан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 2 файл</p>		
--	--	----------------	----------------------------------	---	--	--	--	--	--

Handwritten mark

3.2. 2	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцос, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Үйл ажилл агааны зардла ар	Тооцоо, төсөөлли йн тусгасан танилцуу лгын тоо	"Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль"- ийн танилцуу лгад тооцоо, төсөөлли йг хүргүүлсэ н.	-	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгы г боловсруулс ан байна. /1 танилцуулга/	Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд нэн шаардлагатай салбарын реформ, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах замаар ядуурлыг бууруулж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд төрийн үйлчилгээг хялбаршуулах, чиг үүргийн давхардлыг арилгах замаар төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байх, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах чиглэлд төсвийн зардлын реформыг хэрэгжүүлэхээр тусган боловсруулсан. Мөн макро эдийн засгийн нөхцөл байдлын танилцуулгад 2024 он, 2025 оны төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, тусган боловсруулсан. Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр батлагдсан.	100%	100%
-----------	---	----------------------------	--	---	---	---	---	------	------

							Хавсралт: 3 файл		
3.2. 3	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	Үйл ажилл агааны зардла ар	Танилцуу лгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгэ э хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн	2025 онд улирал бүр дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /4 танилцуулга/	2025 онд улирал бүр дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /4 танилцуулга/	Макро эдийн засгийн 2025 оны I, II улирал болон 2024 оны жилийн эцсийн танилцуулга (Macro diagnostics) тайланг төсвийн секторын улирлын гүйцэтгэл, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн боловсруулж, яамны удирдлагууд болон олон нийтэд англи, монгол хэлээр хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээсэн. Тус тайланд нэгдсэн төсвийн орлого, зарлага, улсын төсвийн хөрөнгө оруулалт, засгийн газрын гадаад өр, төсвийн бодлогын төлөв, тогтвортой байдлын шинжилгээ, төсвийн эрсдэл зэрэг төсвийн секторын холбогдох дүн шинжилгээг хийж, цаашид хэрэгжүүлэх төсвийн бодлогын арга хэмжээг тусган боловсруулсан. Тус улирлын тутмын танилцуулга тайлан нь яамны цахим хуудсанд байршуулж, хэвлэмэл хэлбэрээр яамны удирдлагууд болон холбогдох байгууллагуудад тарааж, мэдээллээр тогтмол хангаж ажилласан болно. Хавсралт: 8 файл	100%	100%
3.2. 4	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн	үйл ажилл агааны зардла ар	Хөгжүүлс эн загварын тоо	2024 онд 3 загвар хөгжүүлсэ н.	-	Загвар хөгжүүлсэн байна. /1 загвар/	Засгийн газрын өр болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн дунд хугацааны (6 жил) төсөөлөл боловсруулах аргачлалыг хөгжүүлж байна. Тухайлбал, бодит ДНБ-г өсөлтийн дундаж , потенциал ДНБ-ий дундаж өсөлт,	100%	100%

14

	тооцоо, төсөөлөлд ашиглана.					<p>Үйлдвэрлэлийн функц ашиглан төсөөлж байна. Харин төсвийн орлогыг мэдрэмжээс хамааруулан төсөөлөх, төсөөллийг тохируулгын утгаар засварлаж байгаа бол төсвийн зардлыг есөлтийн хувиас хамааруулан төсөөлж, тохируулгын утгаар засварлаж байгаа гэх мэт төсөөллийн загваруудыг илүү боловсронгуй болгон хөгжүүлж байна. "Макро эдийн засаг ба уур амьсгал" макро түвшний интеграцчилсан загвар хөгжүүлэх чиглэлд тус загварын гурав дах шатны хөгжүүлэлтийг гүйцэтгэж ажилласан. Мөн төсвийн чиглэлээр Олон улсын валютын сангийн төсвийн эрсдэлийн шинжилгээний загвар аргачлалыг (FRT) төсвийн тооцоо, төсөөлөлд ашиглах, тус загвар аргачлалаар төсөвт голлон нөлөө үзүүлж байгаа эрсдэлийг тодорхойлж, цаашид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад эрсдэлийн үнэлгээ хийх, аргачлалыг боловсруулахад ашиглаж байна.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
3.3.	Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод	-	-	-	-	<p>Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах хүрээнд төсөвт нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, улмаар эдгээр эрсдэлүүдээс сэргийлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга</p>	100%	100%

	эрсдэлийг тодорхойлох;					<p>хэмжээнүүдийг тодорхойлсон. Эрсдэлийг тодорхойлох хүрээнд төсвийн харьцуулалт болон мэдрэмжийн шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэн бөгөөд тэдгээрийн төсөвт хамгийн их нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлсон болно. Мөн тухайн эрсдэлүүдийн төсөвт үзүүлэх магадлал нөлөөллийн хэмжээ зэргийг эрсдэлийн зураглал ашиглан эрэмбэлэн тогтоож, эрсдэлийг бууруулах, удирдах арга хэмжээг тодорхойлсон. Хувилбарт тооцооллын үр дүнгээр худалдааны дайнтай холбоотой шокийн нөлөөгөөр манай улсын нийт экспортын орлого суурь төсөөлөлтэй харьцуулахад хэрхэн буурч болзошгүй талаар дүн шинжилгээг хийсэн. Мөн экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн үнийн бууралт, эдийн засгийн гол салбаруудын өсөлт төсөөллөөс доогуур гарах, эрчим хүчний салбарын өсөлт удаашрах, Засгийн газрын өрийн дарамт нэмэгдэх, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашрах эрсдэлийн магадлал, тэдгээрийн төсөвт үзүүлэх нөлөөний талаар эрсдэлийн тайланд тусган боловсруулсан болно</p> <p>Хавсралт: 4 файл</p>		
--	------------------------	--	--	--	--	---	--	--

3.3. 1	Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгана.	Үйл ажилл агааны зардла ар	Танилцуу лгад туссан тоо	2024 онд батлагдса н бодлогын баримт бичигт эдийн засагт тохиолдо ж болзошгү й эрсдэлийг тодорхой лж тусгасан.	Болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулга д тусгасан байна. /2 танилцуулга/	Болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулга д тусгасан байна. /2 танилцуулга/	Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, мөн нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аар батлуулах хүрээнд макро эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн дэлгэрэнгүй танилцуулгад тус тус тусган боловсруулсан. Энэ хүрээнд худалдааны дайн, хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний тасалдал, зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг зэрэг макро эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, тухай бүр хуулийн хугацаанд иж бүрдлийг бүрэн хангуулж, УИХ-аар батлуулсан. Хавсралт: 3 файл	100%	100%
3.3. 2	Макро эдийн засгийн голлох	Үйл ажилл	Танилцуу лгын тоо	2024 онд сар бүр	-	Сар бүр танилцуулга	Макро эдийн засгийн сарын танилцуулгад нэгдсэн төсвийн	100%	100%

14

	үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	агааны зардлар		танилцуулга бэлтгэсэн		бэлтгэсэн байна. /12 танилцуулга/	орлого, зарлага, тэнцвэржүүлсэн тэнцэл болон засгийн газрын өрийн гүйцэтгэлд тухайн сар бүр дүн шинжилгээ хийж, англи болон монгол хэлээр хянан боловсруулж, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллав. Тус сар тутмын макро эдийн засгийн танилцуулга нь яамны цахим хуудсаар олны нийтэд түгээгдсэн. Түүнчлэн дээрх тайланг MACRO channel MN, MACRO channel EN нэртэй Эдийн засаг, хөгжлийн яамны макро эдийн засгийн мэдээлэл хүргэх Viber суваг үүсгэн англи, монгол хэлээр олон нийтэд хүргэж байна. Хавсралт: 22 файл		
3.3.3	Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана.	Үйл ажилл агааны зардлар	Мэдээллийн тоо	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн	-	Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/	Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, төсвийн секторын статистик гүйцэтгэлийг макро мэдээллийн сан, шипи болон бусад шаардлагатай танилцуулгад тухай бүр шинэчлэн оруулж, power app power bi аппликэйшний тусламжтайгаар удирдлагыг тухай бүр мэдээллээр хангаж ажиллаж байна. Хавсралт: 1 файл	100%	90%
3.4.	Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг	-	-	-	-		Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар	100%	90%

	<p>үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;</p>					<p>хангах хүрээнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулах хүрээнд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдалтай уялдуулан нэгдсэн төсвийн зарлагын шинжилгээг хийсэн. Тус хуулийн төсөл болон холбогдох танилцуулгад төсвийн бодлого, зарлагын дүн шинжилгээнд үндэслэн дунд хугацаанд нийт төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг 2026 онд 32.2 хувь, 2027 онд 30.0 хувь, 2028 онд 28.6 хувь байхаар үе шаттайгаар буурахаар тооцоолон тусгав. Мөн энэ хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх хуулийн шаардлагыг хангаж байхаар урсгал зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг 2026 онд 24 хувь, 2027 онд 23 хувь, 2028 онд 22 хувь байхаар зах зээлд төрийн оролцоог үе шаттай бууруулан тооцоолон, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийн төсөлд тусган боловсруулж, батлуулсан болно.</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							Хавсралт: 3 файл			
3.4. 1	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	Үйл ажилл агааны зардла ар	Тайланд ашигласа н тоо	-	-	Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/	Монгол Улсын нэгдсэн төсвийн тухайн жилийн батлагдсан төсөвт тодотгол хийх нөхцөлүүдэд дүн шинжилгээ хийх хүрээнд эрдэс баялгийн үнэ, тодруулбал зэсийн баяжмал болон нүүрсний хилийн үнийн өөрчлөлт төсвийн орлого төвлөрүүлэлт болон төсвийн бусад үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж байсан талаар дүн шинжилгээг гаалийн ерөнхий газрын статистикийн дата баазаас авсан тоон мэдээлэлд үндэслэн хийж, макро эдийн засгийн улирлын тайлан, танилцуулгад тусгасан боловсруулсан. Энэ хүрээнд макро эдийн засгийн болон төсвийн орлогын төсөөллийг боловсруулахдаа уул уурхайн салбар, тэр дундаа нүүрсний экспортын гүйцэтгэл, Гаалийн ерөнхий газрын (ГЕГ) статистик тоон мэдээллүүдийг суурь параметр болгон төсвийн орлогын шинжилгээнд улирал бүр тогтмол ашиглаж дүн шинжилгээ хийсэн. Тухайлбал, 2025 оны эхний улирлын макро эдийн засгийн танилцуулгын шигтгээнд нүүрсний хилийн үнийн түүхэн мэдээлэлд тулгуурлан жилийн төсөвт тодотгол хийх нөхцөлийг тодорхойлсон болно.	100%	100%	
							Хавсралт: 4 файл			

3.4. 2	Монгол Улсын төсвийн хугацааны эрсдэлийг тодорхойлж танилцуулга бэлтгэн богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгана.	Үйл ажилл агааны зардла ар	Танилцуулгын тоо	-	-	Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/	Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлон тайлан бэлтгэн дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг боловсруулахад суурь мэдээлэл болгон ашиглав. Тодруулбал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах хүрээнд төсөвт нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, улмаар эдгээр эрсдэлүүдээс сэргийлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон. Эрсдэлийн тайланд төсвийн харьцуулалт болон мэдрэмжийн шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэн, тэдгээрийн төсөвт хамгийн их нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлсон болно. Мөн тухайн эрсдэлүүдийн төсөвт үзүүлэх магадлал нөлөөллийн хэмжээ зэргийг эрсдэлийн зураглал ашиглан эрэмбэлэн тогтоож, эрсдэлийг бууруулах, удирдах арга хэмжээг тодорхойлсон. Хувилбарт тооцооллын үр дүнгээр худалдааны дайнтай холбоотой шокийн нөлөөгөөр манай улсын нийт экспортын орлого суурь төсөөлөлтэй харьцуулахад хэрхэн буурч болзошгүй талаар дүн шинжилгээг хийсэн. Мөн	100%	100%
-----------	--	----------------------------	------------------	---	---	--	--	------	------

						<p>экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн үнийн бууралт, эдийн засгийн гол салбаруудын өсөлт төсөөллөөс доогуур гарах, эрчим хүчний салбарын өсөлт удаашрах, Засгийн газрын өрийн дарамт нэмэгдэх, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашрах эрсдэлийн магадлал, тэдгээрийн төсөвт үзүүлэх нөлөөний талаар эрсдэлийн тайланд тусган бсловсруулсан болно.Тус төсвийн эрсдэлийн тайланг нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлж, УИХ-ын нэгдсэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн хугацаанд батлуулсан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
3.5.	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх;	-	-	-	-	<p>Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027- 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хуульд заасны дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Туушин зочид буудалд амжилттай зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийн</p>	100%	100%

							үеэр ирүүлсэн төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд болон бусад төлөөллөөс ирүүлсэн саналыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн дэлгэрэнгүй танилцуулгад тусгасан болно. Хавсралт: 3 файл		
3.5.1	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг холбогдох хууль, журамд заасны дагуу олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Үйл ажилл агааны зардла ар	Хэлэлцүүлэг зохион байгуулсан тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн	Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. /1 хэлэлцүүлэг/	-	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хуульд заасны дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Туушин зочид буудалд амжилттай хамтран зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийн үеэр ирүүлсэн төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд болон бусад төлөөллөөс ирүүлсэн саналыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулгад тусгасан болно. Хавсралт: 3 файл	100%	100%
3.5.2	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны	Үйл ажилл агааны	Тооцоо, төсөөллийн	Монгол Улсын 2025 оны	Макро эдийн засгийн нөхцөл	-	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн	100%	100%

	<p>төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	<p>зардлаар</p>	<p>танилцуулгын тоо</p>	<p>төсвийн тухай хууль</p>	<p>байдал, 2026-2028 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна. /1 танилцуулга/</p>		<p>төсөөллийн тухай хуулийн төслийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тооцоолол, төсөөлөл болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн холбогдох таамаглалд үндэслэн төслийн орлого, зарлага болон өрийн тооцоолол, төсөөллийг боловсруулж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийн төсөл, танилцуулгад тусгасан. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024.04.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 19 дүгээр тэмдэглэлд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу 2024.04.30-ны өдөр "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурал чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2025 оны 5 дугаар сарны 30-ны өдөр баталсан. Мөн төсвийн орлого нүүрсний үнэ болон экспортын орлогын бууралтаас шалтгаалан саарсан эдийн засгийн нөхцөл</p>		
--	--	-----------------	-------------------------	----------------------------	---	--	--	--	--

						<p>байдлаас үүдэлтэй Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуулийн хүрээнд боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлуулсан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 4 файл</p>	
--	--	--	--	--	--	---	--

Үнэлсэн:

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)



/И.Батхүү/

(гарын үсэг)

2025.12.12
(огноо)

Тайлагнасан:

Макро эдийн засгийн бодлогын газрын
Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга
(албан тушаал)

Оюу-Мягмардорж
.....
(гарын үсэг)

/О.Мягмардорж/

2025.12.12
(огноо)